

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.ДЭЛГЭРСАЙХАНЫ  
2022 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлууд дараах хугацаанд хуралдав.**

- 1.1. 2022.07.28-ны өдөр;
- 1.2. 2022.08.05-ны өдөр;
- 1.3. 2022.08.09-ний өдөр;
- 1.4. 2022.08.18-ны өдөр;
- 1.5. 2022.08.25-ны өдөр;
- 1.6. 2022.09.16-ны өдөр;
- 1.7. 2022.10.12-ны өдөр;
- 1.8. 2022.10.14-ний өдөр;
- 1.9. 2022.11.14-ний өдөр;
- 1.10. 2022.11.30-ны өдөр;
- 1.11. 2022.12.12-ны өдөр;
- 1.12. 2022.12.28-ны өдөр;

**2. Аудитын хорооны хурал дараах хугацаанд хуралдав.**

- 2.1. 2022.08.15-ны өдөр.
- 2.2. 2022.12.19-ний өдөр

**3. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал хуралдсан байдал.**

- 3.1. 2022.08.08-ны өдөр;
- 3.2. 2022.10.13-ны өдөр;
- 3.3. 2022.10.24-ний өдөр;
- 3.4. 2022.11.22-ны өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа дараах асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан холбогдох шийдвэр гаргалтад оролцсон. Үүнд:

1. Хувьцаа худалдах зөвшөөрөл олгох;
2. Банкны Тогтворжуулах төлөвлөгөө-2022-ыг шинэчлэн батлах;
3. Банкны 2022 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгох;

4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, гүйцэтгэлтэй танилцах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ДАГ-ын 2022 оны 2, 3-р улирлын аудитын ажлын нэгдсэн тайланг хэлэлцэх;
7. ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах;
8. Банкны 2022 онд баримтлах Эрсдэлийн аппетитын 2 ба 3-р улирлын гүйцэтгэлтэй танилцах;
9. ХХБ-ны хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ХХБ-ны дотоод хяналтын хөтөлбөрийг батлах;
11. Банкны 2022 онд баримтлах “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийн гүйцэтгэл;
12. Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны журам батлах;
13. Банкны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах;
14. ХХБ-ны чанаргүй активын дотоод үнэлгээ;
15. ДАГ болон Ерөнхий аудитын хэлтэсийн захирлыг томилох зэрэг бусад асуудлууд болно.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэрүүд байсан гэж үзэж байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу тайлант хугацаанд банкны холбогдох этгээдтэй хийх 3 хэлцэлд зөвшөөрөл өгөх тухай шийдвэр гаргалтанд саналаа өгсөн.

ТУЗ болон түүний дэргэдэх ажлын албанаас МУ-ын хууль, зохицуулагч байгууллагын дүрэм, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн сайжруулах, ДАГ-ын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, зохистой засаглалыг хангах хүрээнд ахиц дэвшил гарган ажиллаж байна гэж хувьдаа дүгнэж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрмээр хараат бус гишүүнд олгогдсон эрх, үүргийн хүрээнд ажиллахыг удирдлага болгосон болно.

ХХБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн,

Аудитын хорооны дарга,

Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн



Ж.Дэлгэрсайхан

2023 оны 01-р сарын 17

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН  
2022 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит, ээлжит бус хурлууд, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хуралд оролцож холбогдох тогтоолын төсөл, асуудалд саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус дараах хуралд оролцов.**

- 1.1. 2022.07.28-ны өдөр;
- 1.2. 2022.08.05-ны өдөр;
- 1.3. 2022.08.09-ний өдөр;
- 1.4. 2022.08.18-ны өдөр;
- 1.5. 2022.08.25-ны өдөр;
- 1.6. 2022.09.16-ны өдөр;
- 1.7. 2022.10.12-ны өдөр;
- 1.8. 2022.10.14-ний өдөр;
- 1.9. 2022.11.14-ний өдөр;
- 1.10. 2022.11.30-ны өдөр;
- 1.11. 2022.12.12-ний өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

1. ХХБ-ны 2022 оны санхүүгийн тайланг баталгаажуулах хараат бус аультын байгууллагыг сонгох;
2. Хувьцаа худалдах зөвшөөрөл олгох;
3. ХХБ-ны Тогтворжуулах төлөвлөгөө -2022 -г шинэчлэн батлах;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, гүйцэтгэлтэй танилцах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ХХБ-ны Хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;
7. ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
8. ХХБ-ыг хувьцаат компани болгох төлөвлөгөөтэй холботой товч танилцуулга;
9. ХХБ-ны хувьцааг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх андеррайтерийн болон зөвлөх компаниудыг сонгох;
10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ХХБ-ны дотоод хяалтын хөтөлбөрийг батлах;
11. ЦУНДХ-ны журам батлах;
12. ХХБ-ны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах зэрэг болно.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Мөн 2 удаа ТУЗ-ийн дэргэдэх Цалин уррамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хуралд гишүүний хувиар оролцон Хорооны журмын төсөлд саналаа өгснөөс гадна ТУЗ-ийн удирдлагад ажилладаг ДАГ-ын удирдах ажилтны томилгоо, шинээр хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх саналд шийдвэр гаргахад оролцсон болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 3 удаагийн хэлцэлд зөвшөөрөл өгөхөд саналаа өгсөн.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх ажлын албаны зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэх, цар тахлын нөхцөл байдалд зохицон ажиллах тал дээр ахиц дэвшил гарган ажиллаж байна гэж бодож байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллахыг чармайж ирсэн болно.

ХХБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн,

Цалин урамшууллын болон, нэр дэвшүүлэх

хорооны гишүүн



Ж.Болормаа

2023 оны 01 сарын 12